

2026 оны 05 дугаар  
сарын 29-ны өдөр

№: 26/07

Улаанбаатар  
хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Компанийн дүрмийн 8.3.9 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүрэлхүүгийн Эрдэнэбаатарыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон “Улсын их дэлгүүр” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас өөрийнх нь хүсэлтээр чөлөөлсүгэй.
2. Чинбатын Өндэлгэр (РД: ХД84021923)-ийг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Улсын их дэлгүүр” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилсугай.
3. Монгол Улсын хууль тогтоомж, компанийн дүрэм, журам, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний нөхцөлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Өндэлгэрт үүрэг болгосугай.
4. Гүйцэтгэх захирлын үндсэн цалин болон нэмэлт, урамшууллыг түүнтэй байгуулах Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний дагуу тооцон олгохыг Ахлах нягтлан бодогч Д.Чимгээд даалгасугай.
5. Гүйцэтгэх захирал Ч.Өндэлгэртэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Я.Наваанд олгосугай.
6. Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэх, холбогдох өргөдлийн маягтад гарын үсэг зурах, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүлээн авах эрхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Мөнхбаярын Өлзийбат (РД: АИ84122114)-д итгэмжлэн олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН